




INNOVATION
INVESTMENT

x



2024 ОНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



АГУУЛГА

01. КОМПАНИЙН ТУХАЙ

- Компанийн тухай
- Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлс
- Түүхэн замнал
- Компанийн бүтэц
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- Онцлох тоон үзүүлэлтүүд
- Онцлох үйл явдал

02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


- Төлбөрийн зах зээлийн тухай
- QPay-ийн тухай
- QPay-ийн онцлог
- QPay эко систем
- Группийн дунд хугацааны төлөвлөгөө
- Нийгмийн хариуцлага

03. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

- Ерөнхий мэдээлэл
- ТУЗ-ийн үйл ажиллагаа
- ТУЗ-ийн гишүүд
- Гүйцэтгэх удирдлагын баг
- Компанийн бүтэц
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээ
- Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

04. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- Санхүү байдлын тайлан
- Орлого үр дүнгийн тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан



INNOVATION
INVESTMENT

x



КОМПАНИЙН ТУХАЙ

Компанийн тухай

Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлс

Компанийн бүтэц

Түүхэн замнал

Гүйцэтгэх захирлын захидал

Онцлох тоон үзүүлэлтүүд

Онцлох үйл явдал





КОМПАНИЙН ТУХАЙ

Инновэйшн Инвестмент ХК нь 2017 оноос хойш технологийн хурдацтай хөгжилд тулгуурлан иргэдийн өдөр тутмын амьдралын хэв маягийг хялбаршуулах зорилгоор санхүү, төлбөр тооцоо, мэдээлэл технологийн чиглэлээр шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт, менежментийн чиглэлээр үүсгэн байгуулагдсан олон нийтэд нээлттэй хувьцаат компани юм.

Инновэйшн Инвестмент ХК нь группийн хэмжээнд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжүүлэлт, хөрөнгө оруулалт, тэлэлтийн үйл ажиллагааг хариуцан ажилладаг ба QPay үйлчилгээний үйл ажиллагааг удирдах “ККТТ” ХХК, Мерчантуудад чиглэсэн үйлчилгээнүүдийн үйл ажиллагааг удирдах “Дижитал Мерчант Сервисэс” ХХК гэсэн хоёр охин компанитай үйл ажиллагаа явуулж байна.

Инновэйшн Инвестмент ХК-ийн QPay үйлчилгээ нь Монгол улсад хамгийн өргөн хэрэглээтэй дотооддоо хөгжүүлсэн төлбөр тооцооны системд зүй ёсоор тооцогддог ба 2024 онд өдөрт дунджаар 30 тэрбум гаруй төгрөгийн дүнтэй 500 мянга орчим гүйлгээг дамжуулж байна.

Инновэйшн Инвестмент ХК нь стратегийн хүрээнд шинэлэг шийдэлд хөрөнгө оруулах, дэмжлэг үзүүлэх, инновацлаг төслүүдийг дотооддоо хэрэгжүүлж зах зээлд гаргах менежментийн үйл ажиллагаагаар дагнан ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА

Хүний амьдралыг таатай болгох дижитал шийдэлд хөрөнгө оруулалт хийж, тогтвортой ирээдүйг бүтээх үйлсэд хувь нэмрээ оруулна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Технологид суурилсан инновацлаг шийдэлд зохистой хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлж, шинэ үеийн нийгэм, хүмүүсийн амьдралын хэв маягт нийцсэн дижитал дэд бүтцийг бүрдүүлэх үйлсийг манлайлна.



ҮНЭТ ЗҮЙЛС

- Тэмүүлэл
- Хүчтэй түншлэл, харилцаа
- Багийн ажиллагаа
- Хариуцлага
- Ухаалаг
- Хэрэгцээг ойлгодог
- Тэнцвэртэй байдал
- Тогтвортой хөгжил



КОМПАНИЙН БҮТЭЦ

Групп компани



100%

ККТТ

“ККТТ” ХХК

Банк, Финтекийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, Монголбанк болон гүйлгээнд оролцогч бусад байгууллагуудтай түншлэлийн хүрээнд хамтран ажилладаг бөгөөд Монголбанкны тусгай зөвшөөрлүүдийг авч бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, цахим хэтэвч, аппликэйшн хөгжүүлэх болон бэлэн бус төлбөр тооцооны зах зээлд шаардлагатай дэд бүтэц хөгжүүлэх чиглэлээр Монголд болон Олон улсад үйл ажиллагаа явуулж байна.

100%

DMS

“Дижитал Мерчант Сервисэс” ХХК

Мерчантад зориулсан аппликейшн, санхүүгийн менежмент, зээл жуучлал болон зар сурталчилгааны финтек шийдэл буюу SaaS хөгжүүлэх, группийн мерчантын баазыг ханган өргөжүүлж, тэдэнд шаардлагатай нэмэлт үйлчилгээг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

ТҮҮХЭН ЗАМНАЛ



2016

QR кодоор төлбөр хийх анхны хөгжүүлэлтийг дуусгаж, Хаан Банкинд хэрэгжүүлэх гэрээг байгуулсан.

2017

Анхны хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх зорилгоор Группийн толгой компани болох 'Инновэйшн Инвестмент ХК' байгуулагдсан.

2020

Мерчантууд QR нэхэмжлэх үүсгэх боломжтой API-ийн 2.0 хувилбарыг шинээр нэвтрүүлсэн. UnionPay International-тэй хамтын ажиллагааг эхлүүлж, тэдний картын системд холбогдсон

2019

POS/кассын систем хөгжүүлэлтийн хүрээнд үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан шинэ POS API-г боловсруулж, нэвтрүүлсэн.

2018

Мерчантууд болон үйлчилгээ үзүүлэгчид үйлчлүүлэгчдэд зориулан QR нэхэмжлэх үүсгэх боломжтой API-ийн 2.0 хувилбарыг нэвтрүүлсэн

2022

Хятадад хамгийн өргөн хэрэглэгддэг (64 улсад ашиглагддаг) цахим төлбөрийн систем болох WeChat Pay-тэй экосистемийн гэрээ байгуулж, тус үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлсэн.

2023

Технологийн салбарт анх удаа IPO-г амжилттай хийж гүйцэтгэсэн.

2024

Өмнөд Солонгосын №1 цахим төлбөрийн систем болох GLN International-тай хамтран, Өмнөд Солонгосын жуулчдад QPay QR кодыг сканердаж, тухайн улсынхаа төлбөрийн аппуудаар Монгол Улсад төлбөр хийх боломжийг олгосон.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗАХИДАЛ

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг түнш байгууллагууд, хүндэт хэрэглэгч та бүхний амар амгаланг эрэн мэндчилье.

Бид Монгол Улсад анхны мэдээллийн технологийн компанийн IPO-г амжилттай хийснээс хойш 1 жилийн хугацаа өнгөрчээ. Та бүхэнд Инновэйшн Инвестмент ХК-ийн 2024 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнгийн талаар тайлагнан мэндчилж байгаадаа баяртай байна.

Хувьсан өөрчлөгдөж буй зах зээлийн орчинд манай компани стратегийн зорилгын дагуу хурдтай ажиллан, дасан зохицох чадвараа харуулсаар байгаа билээ. Санхүүгийн хувьд бид дижитал төлбөрийн шинэлэг шийдлүүд болон зах зээлийг тэлэх стратегийн санаачилгуудыг харилцагч, түншүүд, ажилтнуудтайгаа хамтран өргөнөөр нэвтрүүлснээр хүчтэй өсөлтийг бий болгосоор байна.

“**...Бид хувьцаа эзэмшигчдэдээ илүү үнэ цэнийг хүргэх, төлбөр тооцооны салбарын хөгжлийг хурдасгах, хэрэглэгч харилцагчдадаа ээлтэй, хялбар, аюулгүй, найдвартай экосистемийг бий болгохыг зорин ажиллаж байна.**”

Үйл ажиллагааны хувьд бид инновацилаг, харилцагч төвтэй, үйл ажиллагааны оновчтой байдлыг чухалчлан, олон улсын дижитал төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж, үйлчилгээгээ Өмнөд Солонгос болон Зүүн өмнөд азийн орнуудад амжилттай нэвтрүүлж чадлаа.

2024 онд бид технологийн тасралтгүй хөгжүүлэлтийг хийж, харилцагчдадаа дижитал гүйлгээний хэрэглээ, аюулгүй байдал, үр ашгийг дээшлүүлсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх боломжийг олгосон, зах зээлээ улам бүр тэлэх байр сууриа баталгаажуулсан жил байлаа.

Цаашид бид Инновэйшн Инвестмент компанийн ирээдүйг өөдрөгөөр харж байгаа ба дижитал төлбөр тооцооны салбар ч өргөжин тэлэх хандлагатай байгаа тул шинээр гарч ирж буй боломжуудыг ашиглах, хувьсан өөрчлөгдөж буй харилцагч, хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад бэлэн байх болно.

Инновэйшн Инвестмент ХК-д итгэл найдвар тавьж, тууштай дэмжлэг үзүүлсэн эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Мөн шаргуу хөдөлмөр, бүтээлч байдал, хичээл зүтгэлээрээ энэхүү амжилтыг авчирсан хамт олондоо чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлж байна.

Хүндэтгэсэн:

G. Juech

Гомбодоржийн Эрдэнэмөнх



ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1. ОРЛОГЫН ТАЙЛАН	2023	2024	Жилийн өсөлт %
Борлуулалтын орлого	13,237,510,103	26,231,629,402	98%
Нийт ашиг	7,196,495,560	14,180,583,973	97%
Тайлант үеийн цэвэр ашиг	5,696,163,389	10,026,153,601	76%
2. БАЛАНС	2023	2024	Жилийн өсөлт %
Эргэлтийн хөрөнгө	17,864,868,924	18,726,231,800	5%
Эргэлтийн бус хөрөнгө	898,855,241	2,985,144,561	232%
Нийт хөрөнгө	18,763,724,165	21,711,376,362	16%
Нийт өр төлбөр	1,316,156,440	6,431,459,821	389%
Нийт эздийн өмч	17,447,567,724	15,279,916,540	-12%
Нийт эздийн өмч ба өр төлбөр	18,763,724,165	21,711,376,362	16%
3. МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2023	2024	Жилийн өсөлт %
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,911,403,450	8,794,939,633	125%
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(375,793,028)	(1,634,036,057)	335%
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	8,610,849,157	(6,510,084,073)	-176%
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,146,459,579	653,778,597	-95%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,853,360,285	13,999,819,864	655%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,999,819,864	14,653,598,461	5%
4. САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2023	2024	
Нийт ашгийн хувь	54.36%	54.06%	
Цэвэр ашгийн хувь	43.03%	38.22%	
Өөрийн хөрөнгийн өгөөж	32.65%	65.62%	
Авлагын эргэц	9.27	10.73	
Эргэлтийн харьцаа	19.88	6.27	
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	13.96	2.94	

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

+16%
НИЙТ ХӨРӨНГӨ

65.6%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН
ӨГӨӨЖ

+76%
ЦЭВЭР АШИГ

+98%
БОРЛУУЛАЛТЫН
ОРЛОГО

ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

2024 он бол гүйлгээний тоо, гүйлгээний үнийн дүн болон борлуулалт зэрэг бүхий л статистик үзүүлэлтийн хувьд өндөр өсөлттэй жил байлаа.

Нэгж гүйлгээний дундаж үнийн дүн

+23.9%

60,024₮

Өдрийн дундаж гүйлгээний үнийн дүн

16.1 ТЭРБУМ ТӨГРӨГ



Өдрийн дундаж гүйлгээний тоо

482.2 МЯНГАН ШИРХЭГ



Сарын дундаж гүйлгээний үнийн дүн

883.5 ТЭРБУМ ТӨГРӨГ




Сарын дундаж гүйлгээний тоо


14.7 САЯ ШИРХЭГ




ГҮЙЛГЭЭНИЙ ТОО /мянган ширхэг/
ЖДӨХ (2021-2024): **81.4%**; YTD: **45.5%**



ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН /тэрбум.төг/
ЖДӨХ (2021-2024): **102.4%**; YTD: **80.3%**



2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ПОС-ийн системүүдэд
Динамик QR үүсгэх
хөгжүүлэлтийг дуусгав

ПОС-ийн системүүдэд холболт хийх API хөгжүүлснээр бүх ПОС төхөөрөмж дээр динамик QR үүсгэж төлбөр хүлээн авдаг болсон. Энэхүү холболтын үр дүнд ПОС төхөөрөмжтэй Динамик холболттой мерчантын тоо нэмэгдэж, бизнесийн орлогын гүйцэтгэлийг хангахад чухал нөлөө үзүүлсэн.




QPay x SocialPay

Голомт банкны SocialPay app-аар QPay QR буюу QPay мерчантууд дээрх QR-ийг уншуулан гүйлгээ хийх, Голомт банкны QR-ийг QPay уншиж гүйлгээ хийх хөгжүүлэлтийг хийж, QPay нэвтэрсэн бүх банкны апп болон воллет, финтек апп-ууд Голомт банкны мерчантийн QR-ийг унших боломж бүрдсэн. Ингэснээр Монгол улсын бүх арилжааны банк QPay-ээр бүрэн төлбөр тооцоо дамжуулдаг болсон.



“EASY INVOICE”
үйлчилгээг нэвтрүүлэв

Онлайн худалдааны салбарт буюу Facebook сошиал орчинд худалдаа хийж байгаа байгууллага болон хувь хүмүүсийн бизнест бодитой дэмжлэг болохоор төлбөрийн нэхэмжлэхийг гар утасны дугаарт мессеж хэлбэрээр илгээх, төлбөр хянах мэдэгдэл бүхий цоо шинэ үйлчилгээг нэвтрүүлсэн. Нэхэмжлэхийг SMS, Email-ээр илгээх, төлбөр хүлээн авах боломжтой динамик линк бүхий Easy Invoice үйлчилгээний хөгжүүлэлтийг бүрэн дуусгаж бодит орчинд нэхэмжлэхүүд илгээн, төлбөр хүлээн авах тестийг амжилттай хийж гүйцэтгэсэн. Ингэснээр тус бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах бүрэн боломжтой болсон.



Хэрэглээний төлбөрийн
“BPAY” үйлчилгээг
нэвтрүүлэв

Төрийн банк ХК-тай хамтран Төрийн банкны системд бүртгэлтэй СӨХ, Контор, Цахилгаан түгээх байгууллагууд болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын системийг нэгтгэн финтек аппликэйшнууд болон банкны аппликэйшнуудад нэвтрүүлж тэдгээрийн хэрэглэгчдэд хэрэглээний төлбөрөө төлөх боломжийг илүү ойртуулах томоохон бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн. BPay үйлчилгээг өнөөдрийн байдлаар Гэрэгэ компанийн +270 киоскуудад нэвтрүүлсэн ба Monpay, Toki, Тэсо Пропертийс, Rocket гэсэн мерчантуудад холбож хэрэглээнд нэвтрүүлсэн.

2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



МХБ II ангилалд дэвшин арилжаалагдаж эхлэв

Инновэйшн Инвестмент ХК-ийн QPAY симболтой үнэт цаас МХБ-ийн ангилал ахих шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж IPO хийснээс хойш нэг жилийн ойн дээрээ буюу 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн МХБ-ийн II ангилалд арилжаалагдаж эхэлсэн.



Хувьцаа эзэмшигчдэдээ 7'697'783'200₮ ногдол ашил олгов

Инновэйшн Инвестмент ХК нь IPO хийснээс хойш хувьцаа эзэмшигчдэдээ Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 15-ны 02/02 тоот тогтоолоор 4 тэрбум төгрөг, 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 05/14 тоот тогтоолоор 3'697'783'200₮, нийт 7'697'783'200₮-ийн ногдол ашгийг тус бүр олгосон.



Монголбанк QRC стандартыг амжилттай нэвтрүүлэв

Монголбанкнаас баталсан "QR кодын мессеж бүтэц, заавар"-ын дагуу нийт ашиглагдаж байсан системийн холболт бүхий мерчантын холболтонд системийн өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүссэн ба 85'000 мерчант талаас нэмэлт хөгжүүлэлтийн зардал болон цаг хугацааны эрсдэл гаргахгүй байхаар тооцоолж, зөвхөн QPay системийн талаас шинэчлэл, өөрчлөлтүүдийг бие даан хийж амжилттай нэвтрүүлсэн.



Нөөц датацентр үүсгэж, найдвартай ажиллагааг хангав

QPay төлбөрийн систем бүхэлдээ эсвэл зарим бүрдэл хэсгүүд бодит цагийн горимоор болон гар аргаар нөөц датацентр лүү шилжин ажиллах техникийн төлөвлөлтийг боловсруулж, өөр байршилд шилжүүлэв. Үндсэн болон нөөц датацентрийн хоорондох сүлжээний холболтын найдвартай байдлыг хангах, Монголбанкны шаардлагад нийцүүлэх төлөвлөлтийг хийж шаардлагатай тоног төхөөрөмжийн суурилуулалтыг хийж дуусгав.



WechatPay төлбөрийн систем

Үнэт цаас гаргагч нь БНХАУ-ын хамгийн өргөн хэрэглээтэй төлбөрийн аппликэйшн болох WeChat Pay үйлчилгээг нэвтрүүлснээс хойш багагүй хугацаа өнгөрсөн ба Монгол улсын Гадаадын Иргэн Харьяатын Газарын цахим үйлчилгээнд системийн холболт хийж Монгол улс руу зорчих цахим виз, оршин суух эрх зэрэг түгээмэл авдаг үйлчилгээний төлбөрийг цахимаар шийдсэнээр гадаадын иргэдэд орон цай, цаг хугацаа хамаарахгүйгээр үйлчилгээ авах нөхцөлийг бодитойгоор бүрдүүлсэн.



GLN International-тэй системийн холболтыг дуусгав

2024 оны 6 дугаар сард SendMN-тэй хамтарч БНСУлсын GLN International групптэй системийн холболт, хөгжүүлэлтийг хийж дуусган эхний ээлжинд БНСУлсын иргэд QPay мерчантууд дээр өөрийн улсад ашигладаг төлбөрийн аппликэйшнээр QR код уншуулан төлбөр тооцоо хийх боломжтой болсон.



PCI DSS стандартын шаардлагыг хангав



Картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS стандартын шаардлагыг бүрэн ханган БНЭУ-ийн SISA байгууллагаар дөрөв дэх жилдээ амжилттай баталгаажилт хийлгэв. Энэ хүрээнд жилд 4 удаагийн эмзэг байдлын үнэлгээ хийлгэн, картын мэдээллийг аюулгүй, нууцлалтай хадгалах, дамжуулах ажлыг тухай бүр хийж ажилласан.



ISO 27001:2013 стандартын баталгаажилтыг хангав

Олон улсын Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 27001:2013 стандартыг Франц улсын Фнор байгууллагаар амжилттай баталгаажилт хийлгэн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр гэрчилгээ хүлээн авсан. Стандартын хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын тогтолцооны шаардлагыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөн ажиллаж байна.

IPO ХИЙХ ҮЕИЙН ТӨСӨӨЛӨЛ БА ГҮЙЦЭТГЭЛ



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Төлбөрийн зах зээлийн тухай
QPay-ийн тухай
QPay-ийн онцлог
QPay эко систем
Группийн дунд хугацааны төлөвлөгөө
Нийгмийн хариуцлага



02

ТӨЛБӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль” 2017 оны 5 дугаар сарын 31-нд батлагдаж, 2018 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж эхэлсэн. Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна Үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээж өгсөн байдаг.

Төлбөр тооцооны системийн үндсэн зорилго нь банк, санхүүгийн салбарт хийгдэж буй төлбөр тооцоог тасралтгүй, найдвартай, шуурхай гүйцэтгэх замаар нийт эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг хурдасгах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал юм. Иймд төлбөрийн систем нь санхүүгийн системийн дэд бүтцийн чухал хэсэг төдийгүй мөнгөний бодлогыг дамжуулах гол суваг болж үйлчилдэг. Сүүлийн жилүүдэд өндөр түвшний технологи нэвтрэхтэй зэрэгцэн зах зээлийн хөгжлийн хандлага, эрэлт шаардлагад нийцсэн бэлэн бус төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж, төлбөр тооцоог түргэн шуурхай, үр ашигтай гүйцэтгэх боломж бүхий шинэ системүүдийг нэвтрүүлэхэд хүргэсэн. Эдгээр системийн үр ашигтай, хэвийн ажиллагаа нь байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, бизнес эрхлэгчдэд санхүүгийн үүргээ биелүүлэх, мөнгөн хөрөнгөө аюулгүй, цаг тухайд нь шилжүүлэх боломжийг олгож байна.

Өнөөдрийн байдлаар төлбөр тооцооны зах зээл дээр доорх үндсэн оролцогчид байна:

- Монголбанк: Зохицуулалт болон Арилжааны банк хоорондын сэтгэлэмэнт, клиринг гүйцэтгэнэ.
- Арилжааны банкнууд: Хадгаламж, зээл, санхүүгийн үйлчилгээ, төлбөрийн карт, цахим хэтэвч, банкны төлбөрийн аппликейшн гэх мэт үйлчилгээ үзүүлж байна.
- Бусад зээлдүүлэгчид болон финтек платформууд: Уламжлалт болон финтект суурилсан Банк бус санхүүгийн байгууллагууд нь зээл, лайфстайл платформ, цахим хэтэвч, санхүүгийн бүтээгдэхүүнүүд гарган үйлчилж байна. Мөн Buy Now Pay Later үйлчилгээ үзүүлэгчид, Монголбанкнаас цахим мөнгөний зөвшөөрөл авсан финтек платформ багтаж байна.




БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛ

МУ-ын бэлэн бус гүйлгээний тоо, үнийн дүн



QPay зах зээлд эзлэх хувь



- 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт бэлэн бус гүйлгээний тоо 2.1 тэрбум ширхэгт хүрч өмнөх оноос 15.6% өссөн бол үнийн дүнгийн хувьд 576 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 29.8% хувиар өсөхөөр байна.
- QPay үйлчилгээгээр хийгдэж буй гүйлгээнүүд нь тогтмол өсч 2023 оны эцсээр нийт бэлэн бус төлбөр тооцооны зах зээлийн 6.9 хувийг эзэлж байсан бол 2024 онд зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлсэний үр дүнд 8.6 хувьд хүрэх хүлээлттэй байна.

ДИЖИТАЛ ХЭТЭВЧ БА ГАР УТАСНЫ ТӨЛБӨР ТООЦОО

- Дижитал хэтэвчийн өсөлт
- Супер АПП
- Embedded Payments

CONTACTLESS PAYMENT

- Тав тух, аюулгүй байдал
- NFC, Tap-and-Pay

ОДОО АВААД ДАРАА ТӨЛ (BNPL)

- PayPal зэрэг том брэндүүд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн
- Залуу үеийн хэрэглэгчид түгээмэл ашиглаж байна.

CRYPTOCURRENCY PAYMENTS

- Крипто төлбөр тооцоо
- Stablecoins

ХИЛ ДАМНАСАН БОЛОН ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР

- Блокчэйн технологийг ашиглан илүү хурдан, хямд шилжүүлэг хийж байна.
- Төлбөрийн брэндүүд олон улсад зах зээлээ тэлж байна.

AI AND MACHINE LEARNING PAYMENT

- Залилан илрүүлэх
- Хэрэглэгчийн санхүүг оновчтой болгох

OPEN BANKING AND API INTEGRATION

- API-д суурилсан системийг түгээн дэлгэрүүлэх
- Түүнд суурилсан шинэ үйлчилгээг хөгжүүлэхэд анхаарч байна.

REAL-TIME PAYMENTS AND INSTANT TRANSFERS

- Бодит цагийн төлбөр тооцооны сүлжээ
- Төлбөр системүүд болон банкуудын хамтарсан шуурхай шилжүүлэг

SUSTAINABILITY AND ETHICAL PAYMENTS

- Хэрэглэгчид өөрсдийн гүйлгээгээр байгаль орчиндоо санаа тавих шийдлийг сонгож байна.

QR КОДЫН ТӨЛБӨР ТООЦОО

- Азийн орнуудад хамгийн түгээмэл, төлбөр хүлээн авах хялбар арга
- Visa, Mastercard брэндүүд QR төлбөрийг нэвтрүүлж байна.

DECENTRALIZED FINANCE (DEFI) & BLOCKCHAIN

- DeFi платформууд
- Виза зэрэг брэндүүд төвлөрсөн бус блокчэйн суурилсан төлбөрийн шийдлүүдийг судалж байна.

LOYALTY PROGRAMS AND REWARDS INNOVATIONS

- Loyalty programs & Cash-back
- Худалдаа үйлчилгээ үзүүлэгчидтэй хамтарч, төлбөр тооцоог идэвхжүүлж байна.

TOKENIZATION AND DATA SECURITY

- Visa, Mastercard зэрэг брэндүүд токенжуулалтыг ашиглаж байна.
- Biometric Payments

ТҮНШЛЭЛ БА ЭКО СИСТЕМИЙН ӨРГӨЖИЛТ

- Төлбөрийн брэндүүд экосистемээ өргөжүүлж, финтек, SME, технологийн компаниудтай стратегийн түншлэл үүсгэж байна.

B2B PAYMENTS

- B2B төлбөр тооцоо нь дэлхийн төлбөрийн зах зээлийн томоохон хувийг бүрдүүлж байна.

QPAY-ИЙН ТУХАЙ

QPay нь QR кодоор төлбөр хийх, апп доторх төлбөрийн шийдэл, вэб суурьтай төлбөрийн системд мэргэшсэн технологийн компани юм.

Бид Монгол Улсын бүх арилжааны банкууд болон финтек компаниудтай төлбөрийн системээ холбосон бөгөөд бизнесүүд болон хэрэглэгчдэд хамгийн хялбар, найдвартай төлбөрийн шийдлийг санал болгож байна.



МОНГОЛ УЛСЫН
ХҮН АМЫН ТОО

3.5 САЯ

QPAY ХЭРЭГЛЭГЧИД

2.8+САЯ

ЖИЛИЙН
ГҮЙЛГЭЭНИЙ ТОО

176.6 САЯ

ЖИЛИЙН
ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН

10.6 ИХ НАЯД

QPAY-ИЙН ОНЦЛОГ



Хэрэглэгчид шууд төлбөр хийх, үйлчилгээний эрхээ хэдхэн секундын дотор сэргээхэд зориулж хэрэглээний болон IPTV төлбөрийн нэхэмжлэлийг IPTV дэлгэц дээр харуулдаг.



Замын болон цагдаагийн торгуулийг QPay QR кодоор үүсгэсэн хялбар төлбөрийн сонголт бөгөөд торгуулийн системтэй холбогдож амжилттай төлөлтүүд нь харагддаг



Урьдчилсан төлбөрт үйлчилгээг QPay QR кодоор хэрэглэгчдэд хаанаас ч үзүүлэх боломжтой ба автобусны буудал, гудамжны тэмдэг гэх мэт



Дугуй түрээслэх үйлчилгээ



Такси дуудлагын үйлчилгээ



Финтекийн гарааны бизнесүүд
Зах зээл дээрх жижиг бизнесүүд



QPAY БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



Easy invoice үйлчилгээгээр төлбөрийн нэхэмжлэхийг худалдан авагчид болон хэрэглэгчдэд ганцаарчилсан болон бүлэг SMS-ээр илгээх боломжтой.



bPay нь хэрэглэгчдэд сар бүрийн хэрэглээний төлбөрүүдийг (түлхүү түрээс, ус, цахилгаан, дулаан, орон сууцны холбооны хураамж) хамтад нь эсвэл тус тусад нь харах, төлөх боломжийг олгодог нэгтгэсэн систем юм.



QPay Wallet аппликейшн нь хэрэглэгчдэд худалдан авалт болон төлбөр хийх боломж олгодог мобайл түрийвч юм. Тус аппликейшн нь ямар ч банкны бүх төлбөрийн картуудыг интеграци хийх боломжтой.

Quick QR


Олон салбартай эсвэл төлөөлөгчтэй бизнесүүд энэ үйлчилгээг ашиглан өөрийн салбар болон төлөөлөгчдөд QR төлбөрийн үйлчилгээг нэмэх, хасах болон удирдах боломжтой.

QPay subscription service

Энэ нь тогтмол үйлчилгээ үзүүлдэг бизнесүүдэд төлбөрийг автоматаар хасдаг үйлчилгээ юм. Хэрэглэгчид Subscription Payment үйлчилгээний нөхцөлүүдийг хянаж, зөвшөөрөх шаардлагатай.



QPay Merchant аппликейшн нь хувь хүмүүс, жижиг, дунд, том бизнесүүдэд QR кодоор төлбөр хүлээн авахад зориулагдсан аюулгүй, хялбар ашиглах боломжтой апп юм



Инновэйшн Инвестмэнт ХК-ийн амжилттай хөгжүүлсэн төсөл болох QPay үйлчилгээ нь өдгөө Монгол улсын бүх арилжааны банк, финтек, воллет апп-уудад нэвтрэн хэрэглэгч мерчантуудад хүссэн апп-аараа төлбөр тооцоо хийх, төлбөрийн хэрэгслийн сонголтот байдлыг аюулгүй, найдвартай, түргэн шуурхайгаар хүргэн ажиллаж байна.

ГРУППИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

БЭЛЭН БУС ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛД БАЙР СУУРИА БЭХЖҮҮЛЭХ, ХАРААТ БУС БАЙДЛЫГ БИЙ БОЛГОХ

Группийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд дотоодын нийт төлбөр тооцооны зах зээлийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, түүний дотор мерчантад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх, мерчантын датад суурилан хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг шинээр хөгжүүлж санал болгох байдлаар идэвхтэй харилцагчийн тоог нэмэгдүүлэхэд чиглэн ажиллахаар төлөвлөж байна. Энэ хүрээнд дунд хугацаанд үндсэн 8 чиглэлд голчлон анхаарч ажиллана.

01. ДОТООДЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ ЗАХ ЗЭЭЛ ЭЗЛЭЛТИЙН ӨСӨЛТ

Төлбөр тооцооны зах зээлийн өрсөлдөөний хурдтай өсөлт, шинэ төрлийн төлбөрийн системүүд үйлчилгээнүүд, олон улсын томоохон төлбөрийн системүүд (Apple Pay, Alipay, WeChat гэх мэт) Монгол улсад эрчимтэйгээр нэвтэрсээр байна. Төлбөр тооцооны зах зээлд байр сууриа бэхжүүлэх, гэнэтийн хүчин зүйлсийн бизнест нөлөөлөх хамаарлыг бууруулах, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, брэндинг, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэн ажиллаж байна.

02. МЕРЧАНТЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТЭЛЭЛТ

Технологийн хурдтай хөгжил, хэрэглэгчийн амьдралын хэв маягийн өөрчлөлттэй уялдан шинэ төрлийн бизнесүүд улам бүр нэмэгдэж байна. Инновэйшн Инвестмент ХК нь Qpay үйлчилгээний харилцагчийн дата мэдээлэлд үндэслэн сегментчлэлийг нарийвчлан тодорхойлж, шинээр бий болж буй бизнесүүдийг өөрийн мерчант болгох тал дээр идэвхтэй ажиллаж байна. Түүнчлэн харилцагч болох алхмуудыг хялбарчилж цахим гэрээ байгуулах, хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх, мерчант элсүүлэлтийг зайнаас хийх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

03. МЕРЧАНТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖСЭН ХАРИЛЦАН АШИГТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Харилцагчийг танин мэдэх процессийг сайжруулах, түүнтэй хамааралтай шинэлэг CRM, Omnichannel гэх мэт системүүдийг нэвтрүүлж, харилцагчийн эрэлт хэрэгцээг тодорхойлох судалгаануудыг тогтмол хэрэгжүүлж эхлээд байна. Мөн харилцагчийн датад үндэслэн хэрэгцээг илрүүлэх, техникийн боломжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна. Харилцагчийн судалгаа болон өгөгдөлд суурилсан анализийг хослуулж, харилцан ашигтай бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгоход төвлөрөн ажиллаж байна.

04. ОЛОН УЛСЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны 11 сарын байдлаар Монгол улсаас гадаад улс оронд аялсан иргэдийн тоо 1.2 саяд хүрч, 500 сая ам.долларын худалдан авалт хийсэн байна. 2024 оны эхний 10 сарын байдлаар Монгол улсад ирсэн жуулчдын тоо 500'000 орчимд хүрсэн ба нэг жуулчин дунджаар 1500 ам.доллар зарцуулдаг бөгөөд нийт 750 сая ам.долларын гүйлгээ хийжээ. Эдгээр гүйлгээг ихэвчлэн Visa, MasterCard, UnionPay зэрэг олон улсын төлбөрийн картуудаар хийдэг байна. Qpay үйлчилгээний олон улсын төлбөр тооцооны чадамжийг нэмэгдүүлж, дотоод гадаадад дурын төлбөрийн апп-аар Qpay уншуулан төлбөр тооцоо хийх боломжийг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна. Хонгконг болон Казакстаны зах зээлд охин компани байгуулж, Төв Азийн зах зээлд нэвтэрч технологийн экспортлогч болох.



ГРУППИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

05. ТЕХНОЛОГИЙН ЧАДАМЖИЙН ӨСӨЛТ

Хиймэл оюун ухаан бизнесийн бүхий л үйл ажиллагаанд хэрэглэгдэж эхэлсэн ба тэр дундаа Монгол байгууллагуудад харилцагчийн үйлчилгээ, цахим залилан, зээлийн үнэлгээ, гүйлгээний эрсдэл, тээвэр логистик, онлайн худалдаа үйлчилгээний салбарт түгээмэл ашиглагдаж байна. Инновэйшн Инвестмент ХК нь 2025 онд өгөгдөл цуглуулах, хадгалах, боловсруулах суурь дэд бүтцээ сайжруулж, байгууллагын хэлтэс бүрд нэн шаардлагатай дэвшилтэт системүүдийг нэвтрүүлэх, технологийн чадамжийг тасралтгүй сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байна.

06. ОРЛОГЫН УРСГАЛЫН ТӨРӨЛЖИЛТ


Бизнесийн орлого бүрдүүлэлтийн төрөлжилтийг нэмэгдүүлэхийн тулд 2024 онд зах зээл, чиг хандлагын суурь судалгааг хийж, түүнд тулгуурлан 2025-2027 оны хооронд хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулсан. Энэ хүрээнд 2024 онд багтаан брэндийн бодлогыг шинэчилж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн дунд хугацааны төлөвлөгөөг гарган хөгжүүлэлтийн ажлуудыг үе шаттайгаар эхлүүлээд байна. Мөн менежментийн туршлагаа ашиглан гарааны бизнесүүдийг бойжуулах, стратегийн онц ач холбогдолтой төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, дотооддоо хөгжүүлэлт хийн бие даан үйл ажиллагаагаа явуулах хүртэл дэмжих.

07. ХАРИЛЦАГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Харилцагчийн үйлчилгээний бүх сувгуудад OMNICHANNEL нэвтрүүлж, холбогдсон түүхүүдийг дэлгэрэнгүй бүртгэх дэвшилтэт CRM систем нэвтрүүлэх төслийг эхлүүлээд байна. Мерчант, харилцагч байгууллагуудын сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэж, процессийн алдааг илрүүлэх, харилцагчид үйлчлэх журам стандартыг тогтмол сайжруулж, харилцагчийн сэтгэл ханамжийг өндөр байлгах тал дээр анхаарч ажиллана.

08. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нөхцөл байдал: Банкны 1 гүйлгээний ард 1 ширхэг А4 цаас ашиглагддаг гэж үзвэл QPay үйлчилгээ нь 2024 онд 176,6 сая ширхэг цаас хэмнэснээр 21'208 мод, 65'117 тонн ус, 3'000м3 нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тус тус хэмнэсэн байна. Үүнээс гадна Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй цахим бизнесүүдийн 90-ээс дээш хувь нь QPay үйлчилгээг голлох төлбөрийн хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь онлайн бизнесүүдийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Төрийн бүх үйлчилгээнд QPay холболтыг хийснээр иргэд олон нийтийн төрийн үйлчилгээ авах хүртээмжийг нэмэгдүүлж, түгжрэл, цаг хугацаа хэмнэхэд бодитой хувь нэмэр оруулан ажиллаж байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД ЧИГЛЭСЭН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

2024 онд Инновэйшн Инвестмент ХК нь олон улсын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх замаар нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэсэн бодлого, санаачилгуудыг хэрэгжүүллээ.

БАЙГАЛЬ ОРЧИН

Цаасны хэрэглээг бууруулснаар бичиг баримтын хаягдал багасаж, хог хаягдлын менежментэд эерэг нөлөө үзүүлж байна.



176.6 сая
ЦААС



21,208
МОД



65,117 ТОНН
УС



3,000m3 CO2
ЯЛГАРУУЛАЛТ

НИЙГЭМ

Төлбөрийн цахим шийдэл ашигласнаар байгууллагуудад байгальд ээлтэй сонголт хийх соёлыг төлөвшүүлж, төлбөр тооцоо хийж буй хэрэглэгчдэд үлгэрлэн нөлөөлж байна.



УЯН ХАТАН АЖЛЫН ЦАГ
08:00-19:00



УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГТ
ХАМРАГДСАН 36
АЖИЛТАН



7 ХОНОГТ 2 ЦАГ
ТОГТМОЛ ДАСГАЛ
ХӨДӨЛГӨӨН



ЭРҮҮЛ МЭНД БОЛОН ОНЦГОЙ
ТОХИОЛДЛУУДАД ТУЛГУУРЛАН
ЦАЛИНТАЙ ЧӨЛӨӨ ОЛГОХ УЯН
ХАТАН БОДЛОГО

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан QR систем, deer link шийдлээр үйл ажиллагааг хөнгөвчилсөн

3 сая

QPay хэрэглэгчид

200K+

QPay мерчант

21 аймагт

QPay үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Ерөнхий мэдээлэл

ТУЗ-ийн үйл ажиллагаа

ТУЗ-ийн гишүүд

Гүйцэтгэх удирдлагын баг

Компанийн бүтэц

Хувьцааны мэдээлэл

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

03

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр:
Инновэйшн Инвестмент ХК (QPAY)

Хэлбэр:
Хувьцаат компани

Регистрийн дугаар:
6183948

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:
Монголын Хөрөнгийн бирж

МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал:
II

Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг:
184,889,160

Бизнесийн үндсэн үйл ажиллагааны салбар:

- Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
- Программ хангамжийн үйлчилгээ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Хувьцааны эзэмчигчдийн бүтэц:

27.45%	“Эн Си Ди Групп” ХХК
10.00%	Шагдарсүрэн Энхбаяр
8.42%	“Юнимедиа Солюшнс” ХХК
8.27%	“Могул” ХХК
7.30%	“ККТТ” ХХК
7.11%	“Айкор Партнерс” ХХК
5.61%	RENTTRACKS JSC
25.85%	Бусад хувьцаа эзэмшигчид

Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 1,483

ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрэмд нийцүүлэн ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосон. Мөн 2024 оны 05 дугаар сарын -27ны өдөр хувьцаат компанийн “ТУЗ- ийн үйл ажиллагааны журам”-ийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Тус журамд ТУЗ- ийн бүрэн эрх, ТУЗ-ийн бүрэлдэхүүн, нэр дэвшүүлэх, гишүүн сонгох, чөлөөлөх, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн хурал, хуралдах журам, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх, ТУЗ-ийн зардал, үйл ажиллагааг дүгнэх, ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулсан байдаг.

ТУЗ-ИЙН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

ТУЗ нь 2024 онд биечлэн, цахимаар, биечлэн болон цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 9 удаа, 77.8 % ба түүнээс дээш хувийн ирцтэй хуралдаж, 22 тогтоол шийдвэр гаргасан. 2024 онд Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо 3 удаа, Аудитын хороо 1 удаа хуралдаж, Эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа хуралдаж, Стратеги хөгжлийн хороо 1 удаа хуралдаж, хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

ТУЗ-ийн дэргэдэх хороод: ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод ажиллаж байна.

Үүнд:


- Аудитын хороо
- Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо
- Эрсдэлийн удирдлагын хороо
- Стратеги хөгжлийн хороо

ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛАЛ

2024 онд Компанийн ТУЗ-ийн цалин, урамшуулал олгоогүй бөгөөд 2024 оны 5 дугаар сараас 2025 оны 4 дүгээр сар хүртэлх Компанийн ТУЗ-ийн цалин, урамшууллыг нөхөж олгохоор 2025 оны 4-р сарын 28-ны өдөр хуралдах ХЭЭХ-р хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Инновэйшн Инвестмент ХК нь IPO хийсний дараах хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлаа 2024 оны 4 дүгээр сарын 28-ний өдөр хийсэн. Тус хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах, Хувьцаат компанийн дүрмийн төслийг батлах болон ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох үндсэн асуудлуудыг баталж шийдвэр гаргасан.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Нэг. Үнэлгээний зорилго

1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн хавсралт болох асуулгын үнэлгээг баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцно.
3. Компанийн нэгдсэн дүнг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой шийдвэр гаргах, салбарын компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
4. Үнэлгээний дүнг үндэслэн компанид тухайлан зөвлөмж, үүрэг, даалгаврыг хүргүүлэх ба тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлно.
5. Үнэлгээгээр эрсдэлтэй гэж дүгнэгдсэн, эсхүл үнэлгээг Хороо болон бирж, мэргэжлийн холбооноос тухай бүр шаардсан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг хангалтгүй гэж тооцно.

Гурав. Үнэлгээний аргачлал

1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.
2. Үнэлгээний нэдсэн дүнд үндэслэн тухай байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:
Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй
3. Авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
4. 70-90 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
5. 50-60 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
6. 49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

Хоёр. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	88%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	67%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	88%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
	Нэгдсэн дүн	72	68	94%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



ТУЗ-ИЙН ДАРГА
А.БАТТАМИР

Мэдээлэл технологийн салбарт
18 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Д.ГАНЗОРИГ

Хөрөнгийн зах зээл, бизнес
санхүүгийн салбарт 16 жил
ажилласан туршлагатай.



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Т.ДАШЦЭРЭН

Мэдээлэл технологийн салбарт
12 жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Ш. УЯНГА

Татвар, санхүүгийн салбарт 20
жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Б.АНХБОЛД

Мэдээлэл технологийн салбарт 12
жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Г.ХАТАНБОЛД

Хөрөнгө оруулалт, менежмент,
мэдээлэл технологийн салбарт 20
жил ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
Б.ЧУЛУУНСҮХ

ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-
ийн үүсгэн байгуулагч, Мэдээлэл
технологийн салбарт 16 жил
ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
У.НАРАНБААТАР

Банк, санхүү, мэдээлэл
технологийн салбарт 20 жил
ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮН
У.МӨНХЗҮЛ

Үл хөдлөх барилга угсралтын
салбарт 8 жил ажилласан
туршлагатай

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Г. ЭРДЭНЭМӨНХ
CEO

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Б. ЭНХБОЛД
CFO

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байгаа.



Д.ЖАНЧИВ
СТО

2021 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Технологи хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



С.ГҮРЖАВ
“ДИЖИТАЛ МЕРЧАНТ СЕРВИСЭС” ХХК

2019 оноос “Дижитал Мерчант Сервисэс” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа.



О.ХОНГОР
CBO


2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирлаар ажиллаж байгаа.



Ц.ГОМБОДОРЖ
CIO

2022 оноос “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирлаар ажиллаж байгаа.

КОМПАНИЙН БҮТЭЦ



“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК-ИЙН БҮТЭЦ

2024 оны байдлаар “Инновэйшн Инвестмент” ХК нь охин компаниудын хамт нийт оны эцсийн байдлаар 39 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

“Инновэйшн Инвестмент” ХК нь TechFin чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Information Technology (IT) компанийн хувьд эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдал нь онцгой ач холбогдолтой байдаг. “Инновэйшн Инвестмент” ХК нь үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийг таних, удирдах, бууруулах ажиллагааг группийн бүхий л түвшинд авч хэрэгжүүлдэг бөгөөд Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам баталж, мөрдөж ажилладаг.

Түүнчлэн эрсдэлийн нөлөөлөл, тохиолдох магадлалын хүчин зүйлсийг харгалзуулсан эрсдэлийн удирдлагын матрицыг баталсан.


Эрсдэлийн түвшин			Магадлал				
			1	2	3	4	5
			Ховор	Магадгүй	Боломжтой	Өндөр	Байнга
Нө лөө лөл	5	Аюултай	5	10	15	20	25
	4	Өндөр	4	8	12	16	20
	3	Дунд	3	6	9	12	15
	2	Бага	2	4	6	8	10
	1	Ач холбогдолгүй	1	2	3	4	5

Схем Эрсдэлийн тоон үнэлгээний матриц

Нөлөөлөл	Их	Эрсдэлийг удирдаж хяна	Эрсдэлийг удирдаж хянах нэн шаардлагатай	Эрсдэлийг зайлшгүй өргөн хүрээнд удирдах
	Дунд	Эрсдэлийг хяналттайгаар хүлээн зөвшөөр	Эрсдэлийг удирдах хүчин чармайлт хэрэгцээтэй	Эрсдэлийг удирдаж хянах нэн шаардлагатай
	Бага	Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх	Эрсдэлийг хяналттайгаар хүлээн зөвшөөр	Эрсдэлийг удирдаж хяна
		Бага	Дунд	Их
Тохиолдох магадлал				

Схем Эрсдэлийн хариу арга хэмжээний үндсэн матриц

Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх шугам



Схем Эрсдэлийн удирдлагын үе шатууд

“Инновэйшн Инвестмент” ХК нь өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлж, уг эрсдэлүүдийг таних, удирдах ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд эрсдэлүүдийг дараах байдлаар тодорхойлдог.

ГОЛ ЭРСДЭЛҮҮД	ТУЛГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ
Мэдээллийн технологийн эрсдэл	Бүтээгдэхүүн үйлчилгээний дэд бүтцийн сервер, сүлжээний тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл үүсэх, программ хангамж, системийн хэвийн ажиллагаа алдагдах, тасалдал үүсэх зэрэг эрсдэл тохиолдох магадлалтай.	Бид эдгээр хүчин зүйлсийн тохиолдох магадлалыг нарийн тооцоолж, урьдчилан сэргийлэх, магадлалыг бууруулах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. Үүнд: Тогтвортой ажиллагааг хангах үүднээс нөөц дата баазуудад серверээ хадгалдаг ба сервисүүдээ виртуалаар олон болгож, үйлчилгээний ачааллыг бууруулах; Төлбөр тооцооны системийн найдвартай ажиллагааг тасралтгүй хангах үүднээс үндсэн болон нөөц дата центрийг үүсгэж өөрийн сервер, тоног төхөөрөмжийг байршуулах; Группийн түвшинд ашиглагдаж буй мэдээллийн системүүд болон тэдгээрийг ажиллуулах хүний нөөц болон үйл ажиллагааг хамруулан мэдээллийн технологийн эрсдэлийн үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа хийж гүйцэтгэх; Үйлчилгээний ачаалал, алдааг тогтмол хянан бүртгэл хийж, Мерчант байгууллага болон банкнуудтай холбоотой сүлжээний асуудлыг мэдсэн даруй асуудлыг шийдвэрлэх; Сервер, системийн хурд гүйцэтгэл, ачааллыг 24 цагийн турш хянах мониторингийн системийг ашиглах; Сүүлийн үеийн хамгаалалтын шийдлийг нэвтрүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авах хөрөнгө оруулалтыг тогтмол хийж ажиллаж байна.
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлд байгууллагын систем рүү халдах, хакерын халдлагад өртөх, санаатай болон санаандгүй байдлаар хөнөөлтэй программ хангамж суурилуулах, вирустуулах, харилцагчийн мэдээлэл алдагдах зэргээс үүдэн учирч болзошгүй эрсдэлүүд багтана.	Бид энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмж, лицензийг худалдан авч үйл ажиллагаанд ашиглахаас гадна Олон улсын ISO 27001:2013 стандартыг амжилттай баталгаажуулан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлээд байна. Мөн төлбөр картын PCI DSS стандартыг 4 дахь жилдээ амжилттай баталгаажуулсан.
Бизнесийн тасалдал, системийн зогсолттой холбоотой эрсдэл	Техник, технологийн хөгжил асар хурдацтайгаар урагшилж байгаа өнөө үед мэдээллийн технологийн салбарт техник, технологийн хоцрогдол болон гэнэтийн системийн зогсолт нь үйл ажиллагааны бүтээмж, зах зээлийн өрсөлдөх чадварыг бууруулах гол хүчин зүйлд тооцогддог.	QPay үйлчилгээний хэрэглээ өдөр ирэх тутам нэмэгдэж байгаатай холбогдуулан суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжүүдийн шинэчлэлийг 2022, 2024 онуудад хийсэн. QPay үйчилгээний гүйлгээний мэдээллийг үндсэн болон нөөц датацентр дээр бодит цагийн горимоор хуулбарлан хадгалж, эрсэдлийн үед шилжин ажиллах боломжийг бүрдүүлсэн. QPay шийдэл нь үндсэн болон нөөц, үүлэн гэх 3 байршилд ажиллаж байгаа бөгөөд аливаа нэгэн системийн доголдол, техник тоног төхөөрөмжийн гэмтэл, цахилгаан интернэтийн тасалдал үүсэхэд 100% нөхөн ажиллах тогтолцоог бий болгосноороо давуу талтай.
Хүний нөөцийн эрсдэл	Компанийн үйл ажиллагаа өргөжих, үйлчилгээний чанар сайжрах, шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүрд хийхэд ажиллах хүчин чухал үүрэг гүйцэтгэдэг. Үйл ажиллагааны бүх түвшний ажилтнуудад тогтвортой, сэтгэл ханамжтай, аюулгүй ажиллах нөхцөлүүдэд анхаарахгүй байх нь үйл ажиллагааны зардлыг өсгөж, ажилтнууд бүтээмжгүй байх, цаашлаад хүний нөөцийн тогтворгүй байдлыг бий болгох эрсдэлтэй.	Бид боловсон хүчний тогтвортой байдал хангагдаж буй эсэх, ажиллах хүчний хомсдолоос зайлсхийх боломжтой эсэх, ажилтнууд ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэхэд хангалттай мэдлэг, нөөц бололцоотой эсэх, удирдлага нь мэргэжлийн түвшинд хэрэгжиж буй эсэхэд байнга хяналт тавин ажилладаг. Бидний хувьд үйл ажиллагаанд шаардлагатай чадварлаг, мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх хүний нөөцийн цогц бодлого, хөдөлмөрийн дотоод журам болон бусад дотоод дүрэм, журмуудыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

ГОЛ ЭРСДЭЛҮҮД	ТУЛГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ
Дотоод процессийн эрсдэл	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлд байгууллагын систем рүү халдах, хакерын халдлагад өртөх, санаатай болон санаандгүй байдлаар хөнөөлтэй программ хангамж суурилуулах, вирустуулах, харилцагчийн мэдээлэл алдагдах зэргээс үүдэн учирч болзошгүй эрсдэлүүд багтана.	Бид энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмж, лицензийг худалдан авч үйл ажиллагаанд ашиглахаас гадна Олон улсын ISO 27001:2013 стандартыг амжилттай баталгаажуулан Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлээд байна. Мөн төлбөр картын PCI DSS стандартыг 4 дахь жилдээ амжилттай баталгаажуулсан.
Нэр хүндийн эрсдэл	Компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандарт алдагдах, мэдээллийн аюулгүй байдал алдагдах, компанийн засаглал, удирдлага менежментийн баг ёс зүй, мэргэжлийн хариуцлага алдах зэрэг асуудалтай холбоотойгоор Мерчант байгууллага, Хэрэглэгчид, олон нийтийн итгэлийг алдах эрсдэлүүд	Бид энэхүү эрсдэлээс сэргийлж ажилтнуудын дунд мэдээллийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулах, аюулгүй байдлын хяналт, шалгалтыг тогтмол явуулах, албан тушаал, чиг үүргийн хүрээнд мэдээллийн нууцлал болон мэргэжлийн ёс зүйг ханган ажиллахыг тусгасан гэрээ байгуулан ажиллаж байна.
Өрсөлдөөний эрсдэл	Сүүлийн жилүүдэд олон улсад хэрэгжиж буй технологийн боловсронгуй шийдлүүд Монгол Улсад олноор нэвтрэн санхүүгийн зах зээл дахь технологийн шийдэл, манай үндсэн үйлчилгээтэй өрсөлдөхүйц, хүмүүсийн эрэлт шаардлагад нийцсэн төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж байгаа нь Хэрэглэгч, Мерчант байгууллагын тоо буурах, үүнийгээ дагаад борлуулалтын орлогод сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг үүсгэх боломжтой байна.	Бид энэ төрлийн эрсдэлээс сэргийлж түнш байгууллагуудтай хамтын ажиллагааг чухалчилж, бүтээгдэхүүн үйлчилгээ бүрдээ зохих шинжилгээ, сайжруулалтыг тогтмол гүйцэтгэж, Мерчант байгууллагуудад тогтмол тусламж, үйлчилгээ болон дэмжлэг үзүүлж, тусгай зөвшөөрлүүдийн шаардлагыг бүрэн хангаж зах зээл дах оролцогчид болон Хэрэглэгчдийн итгэлийг алдалгүй ажиллаж байна.
Эдийн засгийн эрсдэл	- Валютын ханшийн тогтворгүй байдал; - Үнийн өсөлт, инфляц; - Ажилгүйдлийн түвшин; - Түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзэл, нийлүүлэлт; - Төсөв, мөнгөний бодлого; - Хил гаалийн хорио, хязгаарлалт.	Бид боловсон хүчний тогтвортой байдал хангагдаж буй эсэх, ажиллах хүчний хомсдолоос зайлсхийх боломжтой эсэх, ажилтнууд ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэхэд хангалттай мэдлэг, нөөц бололцоотой эсэх, удирдлага нь мэргэжлийн түвшинд хэрэгжиж буй эсэхэд байнга хяналт тавин ажилладаг. Бидний хувьд үйл ажиллагаанд шаардлагатай чадварлаг, мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэх хүний нөөцийн цогц бодлого, хөдөлмөрийн дотоод журам болон бусад дотоод дүрэм, журмуудыг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
Бусад салбарт гарах эрсдэл	“ККТТ” ХХК нь онлайн худалдаа, банк санхүү, финтек, жижиглэн худалдаа, телефон сүлжээ зэрэг олон салбар дахь Мерчант байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг. Үүнтэй холбоотойгоор харилцагч мерчант байгууллагуудад үүсэх аливаа нэгэн эрсдэлүүд нь компанийн үйл ажиллагаа, борлуулалтад мөн сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай.	Тиймээс бид мерчантуудад зориулсан үйлчилгээгээрээ дамжуулан Мерчантуудын бизнесүүдэд анхаарч мерчантын ангилал, хэрэгцээ тус бүрд нийцэх, найдвартай, хялбар, хурдан үйлчилгээг нэвтрүүлж, харилцагчаа халамжлах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна

ГОЛ ЭРСДЭЛҮҮД	ТУЛГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ	АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ
Давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл	Байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн гэх мэт онцгой байдал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан үйл ажиллагаа, эрчим хүч, интернэт доголдох эрсдэлийн нөлөөлөл нь компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй.	Байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн гэх мэт онцгой байдал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан үйл ажиллагаа, эрчим хүч, интернэт доголдох эрсдэлийн нөлөөлөл нь компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй.
Үнэт цаастай холбоотой эрсдэл	Үнэт цаасны зах зээлд гаргасан хувьцааны үнэ хэлбэлзэж буурах, арилжааны идэвх багасах, хөрвөх чадвар муу байх, ногдол ашиг олгох эсэх зэрэг эрсдэлүүд.	Нээлттэй хувьцаат компани болсноор үнэт цаастай холбоотой дүрэм, журмуудыг мөрдөж, шаардлагатай шимтгэл хураамжийг төлөх, тайлан мэдээллийг цаг тухайд олон нийтэд хүргэж байх хэрэгтэй. Эдгээр асуудлуудыг ажлын төлөвлөлтөд тусган ажиллаж байна. Ногдол ашигтай холбоотой шийдвэрийг ТУЗ гаргаж, ХЭХ-аар баталдаг бөгөөд ирээдүйд ногдол ашиг тараахгүй байх, хөрөнгө оруулагчдын хүлээлтээс бага хэмжээгээр ногдол ашиг тараах зэрэг эрсдэлийн хүчин зүйлс үүсэх боломжтой тул анхаарч ажиллаж байна.
Хөрвөх чадварын эрсдэл	Хөрвөх чадварын эрсдэлд компани ирээдүйн өр төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулж чадахгүйгээс үүдэн санхүүгийн тогтвортой байдал алдагдах, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж чадахгүй болох эрсдэл.	Инновэйшн инвестмент ХК нь өр төлбөр, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг ханган ажилладаг бөгөөд 2024 оны байдлаар нийт хөрөнгөнд эзлэх өөрийн хөрөнгийн хувь дунджаар 72%-тай, нийт эргэлтийн хөрөнгийн 73%-ийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө бүрдүүлж байгаа нь компанийн өр төлбөрийг хугацаанд нь барагдуулж чадахгүй байх эрсдэл харьцангуй бага байгааг харуулж байна.
Зардал хэтрэх эрсдэл	Групп компани болон охин компаниудын үйл ажиллагаанд аливаа тоног төхөөрөмж, серверийн үнийн өсөлт, хор хөнөөлтэй программаас үүдэлтэй болон бусад гаднын хүчин зүйлсээс хамааралтай үүсэх гэнэтийн эвдрэл, эсвэл мерчант байгууллагуудтай холбоотой үүссэн томоохон асуудал зэрэг гэнэтийн төлөвлөгдөөгүй эрсдэлээс үүдэлтэйгээр төлөвлөсөн зардал их хэмжээгээр нэмэгдэх магадлалтай.	Энэ төрлийн эрсдэлүүдийг тохиолдох магадлалыг бууруулах зорилгоор бид ажилтнууд болон эрх бүхий албан тушаалтнуудад үйл ажиллагааны болон мэдээллийн аюулгүй байдлын журам, хор хөнөөлтэй программаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг тогтмол өгч, хэрэгжилтэд хяналт тавьдгаас гадна мэдээллийн аюулгүй байдлын стандарт, шаардлагын нууцлал, аюулгүй байдлыг ханган олон улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулан ажиллаж байна. Түүнчлэн, “Үйл ажиллагааны эрсдэлийн журам”-д заасны дагуу үйл ажиллагааны эрсдэлийн сан байгуулж, шаардлагатай тохиолдолд тус эрсдэлийн санг хуримтлагдсан ашгаас байгуулан ажиллаж байна.
Борлуулалтын орлогын төсөөлөл биелэхгүй байх эрсдэл	Эдийн засгийн нөхцөл байдал муудах, зах зээлд компанийн үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг орлох бүтээгдэхүүн, үйлчилгээ гарч ирэх, гадаад өрсөлдөгч Монгол Улсын зах зээлд нэвтрэх, хэрэглэгчдийн итгэлийг алдах зэрэгтэй холбоотойгоор борлуулалтын төсөөлөл биелэхгүй байх эрсдэл	Бид зах зээл дахь анхдагчийн давуу тал, байр сууриа бэхжүүлж, Түншүүд болон гол Мерчант байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, Хэрэглэгчдийн дунд үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ таниулж чадсан ба өнгөрсөн хугацааны түүхэн мэдээллээс QPay ашиглан төлбөр тооцоо хийх гүйлгээний тоо хурдацтай нэмэгдэж буй нь энэ төрлийн эрсдэлийн нөлөөллийг бууруулах томоохон хүчин зүйл болж байна. Мөн бид мэдээллийн аюулгүй ажиллагааны олон улсын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа нь аливаа харилцагчдын мэдээлэл алдагдсанаар харилцагчдын итгэл алдах аливаа эрсдэл үүсэхээс сэргийлэхэд ихээхэн түлхэц үзүүлж байна.

ХУВЬЦААНЫ ХАНШ

2024 онд нийт 6.7 сая ширхэг хувьцаа 1.5 тэрбум төгрөгөөр арилжигдсан бөгөөд арилжааны дундаж ханш 223.26 төгрөг байлаа.



ДЭЭД ЦЭГ

MNT 260.19

ДООД ЦЭГ

MNT 209.70

EPS харьцаа

54.2

P/B харьцаа

2.60

P/E харьцаа

3.97

Өдрийн дундаж арилжаа

Хувьцааны тоо:

Арилжааны дүн:

28.018

6,217,554₮

Сарын дундаж арилжаа

Хувьцааны тоо:

Арилжааны дүн:

555,685

123,314,823₮

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

IPO хийснээс хойш нийт 11.4 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилаад байна.

4.0₮

Ногдол ашиг олгохоор зарласан огноо:
2024/02/15-ны өдрийн 02/02 тоот тогтоол
Ногдол ашгаа хуваарилав.
2024/04/15

2023 оны жилийн эцэс

3.7₮

Ногдол ашиг олгохоор зарласан огноо:
2024/12/04-ний өдрийн 05/14 тоот тогтоол
Ногдол ашгаа хуваарилав.
2024/12/24

2024 оны I хагас

3.7₮

Ногдол ашиг олгохоор зарласан огноо:
2025/02/07-ны өдрийн 05/30 тоот тогтоол
Ногдол ашгаа 2025/04/30-ны өдрийн
дотор хуваарилахаар шийдвэрлэв.

2024 оны II хагас

18% ногдол
ашгийн
өгөөж

“Инновэйшн Инвестмент” ХК
нь 2024 онд нэгж хувьцаанд
40₮ ногдол ашиг
тарааж нийт **7.4 тэрбум төгрөг**
хуваарилахаар шийдвэрлэсэн.

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Эзлэх хувь	Татан төвлөрүүлсэн мөнгөн дүн	Зарцуулсан дүн
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	22.5%	1,871,991,911	135,948,166
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа	30.0%	2,495,989,215	0
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	15.0%	1,247,994,608	1,061,274,656
4	“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	25.0%	2,080,003,050	2,080,003,050
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	7.5%	623,985,266	0
НИЙТ		100.0%	8,319,964,050	3,277,225,872

- 2023 оны 12 дугаар сард нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн.
- 2024 онд төлөвлөж байсны дагуу QPay төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр 1,061,274,656 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалт хийсэн бөгөөд үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу “Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа”-нд зориулагдах 1,247,994,608 төгрөгөөс зарцуулсан.
- Мөн 2024 оны 2 дугаар хагаст QPay үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой кампанит ажлыг явуулж байгаа ба тус үйл ажиллагаатай холбоотой 135,948,166 төгрөгийн зардал гарсан. Үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн “Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үйл ажиллагааны тэлэлт” хэсгээс зориулалтын дагуу зарцуулаад байна.
- Бид одоогоор нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 39%-ийг зориулалтын дагуу зарцуулаад байгаа ба үлдсэн хөрөнгийг зориулалтын дагуу 2025 болон 2026 онуудад зарцуулахаар төлөвлөж байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан
Орлого үр дүнгийн тайлан
Өмчийн өөрчлөлтийн тайлан
Мөнгөн гүйлгээний тайлан

04



“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 даахэр
ЮНЭСКО-ийн гудамж-31
Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар
14230, Монгол Улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

Инновэйшн Инвестмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид Инновэйшн Инвестмент ХК (цаашид “компани” гэх) болон түүний охин компаниуд (хамтад нь “групп” гэх) -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан,
- Нэгтгэсэн ашиг алдагдал, ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан
- Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, Инновэйшн Инвестмент ХК болон түүний салбар компаниуд (хамтад нь “групп” гэх) -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх Нэгтгэсэн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын Ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус группээс хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.



Аудитын аргачлалын хураангуй

Аудитын цар хүрээ	• Энэхүү аудитын цар хүрээнд тус группийн охин компаниуд болох “ККТТ” ХХК болон “Дижитал Мерчант Сервисэс” ХХК багтсан болно
Материаллаг байдал	• Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 391,398.2 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо татварын өмнөх ашгийн 3%-иар тооцсон.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Группийн удирдлага эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь нэгтгэсэн санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ группийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн ул итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Группийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.



- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад нэгтгэсэн санхүүгийн тайлангийн өрөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компани доторх бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай зохистой нотолгоо олж авдаг. Бид группийн аудитыг чиглүүлэх, хянах, гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтдээ хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг “Компанийн тухай” хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнёр нь Н.Эрдэнэцог болно.



Огноо:

Н.ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

Огноо:

АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ
ОРЛОГЫН ТАЙЛАН

	/мянган төгрөгөөр/	
	2023	2024
Борлуулалтын орлого	13,237,510	26,231,629
Борлуулалтын өртөг	6,041,015	12,051,045
Нийт ашиг (алдагдал)	7,196,496	14,180,584
Борлуулалт, маркетингийн зардал	564,484	805,563
Ерөнхий ба удирдлагын зардал	1,698,693	1,941,064
Бусад орлого	1,210,184	-
Бусад зардал	161,084	45,307
Үйл ажиллагааны цэвэр ашиг	5,982,418	11,388,649
Хүүний орлого	414,802	1,608,190
Ногдол ашгийн орлого	-	69,105
Санхүүгийн зардал	12,897	2,188
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,164)	(13,528)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	74	(3,622)
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,380,232	13,046,606
Орлогын татварын зардал	(684,069)	(3,020,452)
Татварын дараах ашиг (алдагдал)	5,696,163	10,026,154
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	5,696,163	10,026,154
Нэгж хувьцаанд ноогдох ашиг суурь ашиг	31	54

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Хөрөнгө	/мянган төгрөгөөр/	
	2023	2024
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	13,999,820	14,653,598
Дансны авлага	1,427,598	2,444,663
Татвар, НДШ-ийн авлага	14,611	2,019
Бусад авлага	415,741	563,558
Бусад санхүүгийн хөрөнгө	1,924,531	944,832
Бараа материал	2,020	2,737
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	80,549	114,825
Эргэлтийн хөрөнгийн дүн	17,864,869	18,726,232
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	624,074	1,229,171
Биет бус хөрөнгө	216,070	505,973
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	1,250,000
Хойшлогдсон татварын хөрөнгө	58,711	-
Эргэлтийн бус хөрөнгө	898,855	2,985,145
Нийт хөрөнгө	18,763,724	21,711,376
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	805,601	1,361,785
Цалингийн өглөг	37,543	47,166
Татварын өр	433,808	1,248,784
НДШ-ийн өглөг	393	3,249
Хүүний өглөг	23	-
Ногдол ашгийн өглөг	-	3,697,783
Урьдчилж орсон орлого	1,800	-
Богино хугацаат өр төлбөр	617	1,117
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,279,784	6,359,884
Урт хугацаат өр төлбөр		
Хойшлогдсон татварын өр		71,576
Бусад урт хугацаат өр төлбөр	36,372	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	36,372	71,576
Өр төлбөрийн нийт дүн	1,316,156	6,431,460
Капитал ба нөөц		
Хувьцаат капитал	4,425,440	4,284,927
Нэмж төлөгдсөн капитал	4,653,188	3,554,513
Хуримтлагдсан ашиг	8,368,939	7,440,476
Эзэмшигчдийн өмчийн дүн	17,447,568	15,279,917
Өр төлбөр болон эзэмшигчдийн өмчийн дүн	18,763,724	21,711,376

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	/мянган төгрөгөөр/		
	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг /алдагдал	Нийт
2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	-	2,668,161	6,169,161
НББ-ийн тооцооллын бодлогын өөрчлөлтийн алдаа	-	4,615	4,615
Залруулсан үлдэгдэл	-	2,672,776	6,173,776
Тайлант жилийн ашиг	-	5,696,163	5,696,163
Өмчид гарсан өөрчлөлт	4,653,188	-	5,577,628
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	4,653,188	8,368,939	17,447,567
Өмчид гарсан өөрчлөлт (1)	(1,098,675)	-	(1,239,188)
Тайлант жилийн ашиг	-	10,026,154	10,026,154
Зарласан ногдол ашиг	-	(10,954,616)	(10,954,616)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	3,554,513	7,440,477	15,279,917

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2023	2024
/мянган төгрөгөөр/		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	14,678,301	29,286,589
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	13,761,945	27,842,043
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	35	233
Буцаан авсан албан татвар	47,795	-
Бусад мөнгөн орлого	868,525	1,444,313
Мөнгөн зарлагын дүн	11,709,895	20,491,649
Ажиллагчдад төлсөн	1,279,773	1,558,490
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	340,015	414,988
Бараа материал худалдан авахад төлсөн	9,472	8,518
Ашиглалтын зардалд төлсөн	-	20,994
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	157	392
Татварын байгууллагад төлсөн	1,668,329	5,300,249
Даатгалын төлбөрт төлсөн	2,813	-
Бусад мөнгөн зарлага	8,409,338	13,188,019
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,968,406	8,794,940
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	4,452,376	1,975,403
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	3,992,456	414,630
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	46,916	267,021
Хүлээн авсан хүүний орлого	413,004	1,228,103
Хүлээн авсан ногдол ашиг	-	65,648
Мөнгөн зарлагын дүн	3,882,164	3,609,439
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	81,032	1,287,015
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		100,000
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	3,653,247	2,215,904
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	147,885	6,520
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	570,212	(1,634,036)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн	8,747,873	103,027
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10	103,027
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	8,747,864	-
Мөнгөн зарлагын дүн	136,283	6,613,111
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	136,283	38,041
Төлсөн ногдол ашиг	-	6,575,070
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,611,591	(6,510,084)
Валютын ханшийн зөрүү	(3,748)	2,959
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	12,146,460	653,779
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,853,360	13,999,820
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,999,820	14,653,598



 I-INVESTMENT.MN

 +976 76102211

 INFO@QPAY.MN

 МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ХАН-УУЛ
ДҮҮРЭГ, 15-Р ХОРОО, МАХАТМА ГАНДИГИЙН ГУДАМЖ,
НМ ОФФИС, 8 ДАВХАР

IR CONTACT

 П.МӨНХТУЯА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР

 88004829

 MUNKHTUYA.P@QPAY.MN

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Инновэйшн Инвестмент УБ-ийн гэрчилгээний дугаар: 9007001023 Үнэт цаасны код: MN0QPAY05709 Утасны дугаар: 76102211
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мэдээлэл технологийн үйл ажиллагаа Программ хангамжийн үйлчилгээ
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Грант торнтон аудит ХХК СЗХ-нд бүртгүүлсэн огноо 2021.12.14
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	184,889,160 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Хөрөнгө оруулагчийн харилцаа хариуцсан менежер П.Мөнхтуяа Хянасан: Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд

1. Тайланг жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/

Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	2024 он /мян.төг/	2023 он /мян.төг/
	Хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	18,726,232	17,864,869
	Эргэлтийн бүс хөрөнгийн дүн	2,985,144	898,855
	Нийт хөрөнгө	21,711,376	18,763,724
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	6,359,884	1,279,785
	Урт хугацаат өр төлбөр	71,575	36,372
	Нийт өр төлбөр	6,431,459	1,316,157
	Эздийн өмчийн дүн	15,279,917	17,447,567
	Нийт өр төлбөр болон эздийн өмчийн дүн	21,711,376	18,763,724
Орлогын тайлан	Үзүүлэлт	2024 он /мян.төг/	2023 он /мян.төг/
	Борлуулалтын орлого	26,231,629	13,237,510
	Өртөг	(12,051,045)	(6,041,015)
	Нийт ашиг/(алдагдал)	14,180,584	7,196,495
	Борлуулалт, маркетингийн зардал	(805,563)	(564,484)
	Ерөнхий удирдлагын зардал	(1,941,549)	(1,698,693)
	Бусад орлого	(0)	1,210,184
	Бусад зардал	(45,307)	(161,084)
	Үндсэн үйл ажиллагааны үр дүн	11,388,165	5,982,418
	Санхүүгийн орлого	1,677,294	414,802
	Санхүүгийн зардал	(1,703)	(12,897)
	Үндсэн хөрөнгө борлуулсаны олз	(3,622)	74
	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг/алдагдал	(13,528)	(4,164)
	Орлогын татварын өмнөх ашиг/(алдагдал)	13,046,606	6,380,232
	Орлогын татварын зардал/(буцаалт)	(3,020,452)	(684,069)
	Тайланг жилийн ашиг/(алдагдал)	10,026,154	5,696,163

Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт		Нийт /мян.төг/
	2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл		6,169,161
	НББ-ийн тооцооллын бодлогын өөрчлөлтийн алдаа		4,615
	Залруулсан үлдэгдэл		6,173,776
	Тайлант жилийн ашиг		5,696,163
	Өмчид гарсан өөрчлөлт		5,577,628
	2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл		17,447,567
	Өмчид гарсан өөрчлөлт		(1,239,188)
	Тайлант жилийн ашиг		10,026,154
	Зарласан ногдол ашиг		(10,954,616)
	2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл		15,279,917

Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	2024 он /мян.төг/	2023 он /мян.төг/
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,794,941	2,968,406
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,634,037)	570,211
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(6,510,084)	8,611,591
	Валютын ханшийн зөрүү	2,959	(3,748)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	653,778	12,146,460
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,999,820	1,853,360
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,653,598	13,999,820

1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
	Аудитын дүгнэлтийг хавсралтаар хүргүүлэв. /Хавсралт 1/
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/
	Аудитын дүгнэлтийг хавсралтаар хүргүүлэв. /Хавсралт 1/
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд	2024	2023
		Нийт ашгийн хувь	54%	54%
		Үйл ажиллагааны ашгийн хувь	43%	45%
		Цэвэр ашгийн хувь	38%	43%
		Өөрийн хөрөнгийн өгөөж	66%	33%
		Нэгж хувьцаанд ногдох ашиг	54.23	30.81

2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Хөрвөх чадварын харьцаа	2024	2023
		Эргэлтийн харьцаа	2.94	13.96
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	2.94	13.96
		Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	42.09%	7.54%

2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	2024 оны байдлаар QPay үйлчилгээ нь гүйлгээний тоогоор Монгол улсын хэмжээнд хийгдсэн нийт төлбөр тооцооны 9% орчмыг, гүйлгээний дүнгээр 2% орчмыг хийж гүйцэтгэж байгаа бол QRтөлбөр тооцооны салбартаа 90 гаруй хувийг дангаар хийж гүйцэтгэж байна. Олон улсын зах зээлд тэр дундаа Азийн бүс нутагт QRC төлбөр тооцоо нь эрчимтэй нэмэгдэж байгаа нь бидэнд төлбөр тооцооны зах зээлд тэлэлт хийх нөөц боломж байгааг харуулж байгаа юм. Төлбөр тооцооны зах зээлд байр сууриа бэхжүүлэх үүднээс 2025 оноос эхлэн бүтээгдэхүүн хөгжүүлэлт, брэндинг, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр төлөвлөдөг байна. Төлөвлөгөөт ажлуудаас дурдвал: • Private Acquiring System нэвтрүүлэх, Гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх; • Мерчантад зориулсан Super App (Soft POS) бүтээгдэхүүн хөгжүүлэх; • Мерчантийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх болон сайжруулах гэх мэт дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна.
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй, 2022 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Зээлийн өр төлбөр байхгүй.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл: • 2024/06/06-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №05/06 тоот тогтоолоор Хувьцаа эзэмшигч Могул ХХК-ийн охин компани болох Ай Ти Зон ХХК-аас дэд бүтцийн тоног төхөөрөмж худалдаж авах шийдвэр гаргасан. • 2024/06/27-ны өдрийн ТУЗ-ийн хурлын №05/08 тоот тогтоолоор охин компани болох ККГТ ХХК-д нэмж хөрөнгө оруулалт хийх тухай шийдвэр гаргасан.	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
	Компани нь голлох удирдлагуудад олгох цалин хөлс, урамшуулал, тэтгэмжийн асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох дүрэм журам, Инновэйшн Инвестмент ХК-ийн “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 14 дүгээр бүлэг, Хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хүрээнд тооцон олгож байна. Тайлант онд голлох удирдлага ТУЗ-ийн цалин хөлс, урамшуулалын зардал нь 767,399 мянган төгрөг байна.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Инновэйшн Инвестмент ХК нь IPO хийсний дараах хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хурлаа 2024 оны 4 дүгээр сарын 28-ний өдөр хийсэн. Тус хурлаар Компанийн жилийн үйл ажиллагааны болон аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах, Хувьцаат компанийн дүрмийн төслийг батлах болон ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилох үндсэн асуудлуудыг баталж шийдвэр гаргасан.

Төлөөлөн удирдах зөвлөл

Засаглалын бүтэц, үйл ажиллагаа: 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрэмд нийцүүлэн ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн буюу нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосон. Мөн 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр хувьцаат компанийн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь сар бүр хуралдаж, эрх үүргийнхээ хүрээнд шийдвэрүүдийг гарган ажиллаж байна.

Компанийн одоогийн ТУЗ нь дараах бүтэц бүрэлдэхүүнтэй байна.

ТУЗ-ийн дарга А.Баттамир
 ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Ганзориг
 ТУЗ-ийн хараат бус гишүүн Т.Дашцэрэн
 ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Уянга
 ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Чулуунсүх
 ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Анхболд
 ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Хатанболд
 ТУЗ-ийн ердийн гишүүн У.Мөнхзул
 ТУЗ-ийн ердийн гишүүн У.Наранбаатар
 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Л.Золбаяр

ТУЗ-ийн дэргэдэх хороод: ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод ажиллаж байна. Үүнд:

- Аудитын хороо
- Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо
- Эрсдэлийн удирдлагын хороо
- Стратеги хөгжлийн хороо

ТУЗ-ийн ажлын товч тайлан: ТУЗ нь 2024 онд биечлэн, цахимаар болон хосолсон хэлбэрээр нийт 9 удаа, 77.8% ба түүнээс дээш хувийн ирцтэй хуралдаж, 22 тогтоол шийдвэр гаргасан. 2024 онд Цалин урамшуулал, нэр дэвшүүлэлтийн хороо 3 удаа, Аудитын хороо 1 удаа хуралдаж, Эрсдэлийн удирдлагын хороо 1 удаа хуралдаж, Стратеги хөгжлийн хороо 1 удаа хуралдаж, хороодын чиг үүргийн хүрээнд хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт, зөвлөмж гаргасан.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт:

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээний загварын дагуу компани өөрийгөө дараах байдлаар үнэлсэн болно.

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
5	Эрсдэлийн удирдлага	8	7	88%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	67%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	88%
8	Компанийн соёл	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
	Нэгдсэн дүн	72	68	94%

Гүйцэтгэх удирдлага

Компанийн дүрмийн 12 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирал нь Компанийн дүрэм, Компанийн засаглал болон бүтэц зохион байгуулалтын баримт, ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тус тусын харьяалах асуудлуудыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий удирдах түвшний албан тушаалтнууд ажилладаг.

	Гүйцэтгэх удирдлагын баг Гүйцэтгэх удирдлагын баг нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмох Санхүү эрхэлсэн захирал Б.Энхболд Бизнес хөгжил хариуцсан захирал О.Хонгор Технологи хариуцсан захирал Д.Жанчив Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан захирал Ц.Гомбодорж Ерөнхий нягтлан бодогч С.Ундармаа Охин компани болох Дижитал Мерчант Сервисэс ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Гүржав																														
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл Сүүлийн жилүүдэд олон улсад хэрэгжиж буй технологийн боловсронгуй шийдлүүд Монгол Улсад олноор нэвтрэн санхүүгийн зах зээл дэх технологийн шийдэл, манай үндсэн үйлчилгээтэй өрсөлдөхүйц, хүмүүсийн эрэлт шаардлагад нийцсэн төлбөрийн шинэ дэвшилтэт хэрэгслүүд хурдацтайгаар бий болж байгаа нь Хэрэглэгч, Мерчант байгууллагын тоо буурах, үүнийгээ дагаад борлуулалтын орлогод сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг үүсгэх боломжтой байна. Мөн иргэдийн амьдралын хэвшил өөрчлөгдөж, мэдлэг мэдээлэл илүү хурдацтайгаар тархах болсон өнөө үед бэлэн бус төлбөр тооцооны салбарт бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд зах зээлд өрсөлдөөн нэмэгдэх магадлалтай байна. Бид энэ төрлийн эрсдэлээс сэргийлж түнш байгууллагуудтай хамтын ажиллагааг чухалчилж, бүтээгдэхүүн үйлчилгээ бүрдээ зохих шинжилгээ, сайжруулалтыг тогтмол гүйцэтгэж, Мерчант байгууллагуудад тогтмол тусламж, үйлчилгээ болон дэмжлэг үзүүлж, тусгай зөвшөөрлүүдийн шаардлагыг бүрэн хангаж, зах зээл дэх оролцогчид болон Хэрэглэгчдийн итгэлийг алдалгүй ажиллаж байна.																														
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/ Инновэйшн Инвестмент ХК нь 2024 оны 12 дугаар сарын байдлаар 1483 хувьцаа эзэмшигчидтэй байгаа бөгөөд тайлант хугацаанд дахь нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид түүний эзэмшиж буй хувь хэмжээг доорх хүснэгтээр харууллаа. <table><tr><th>№</th><th>Хувьцаа эзэмшигчдийн нэр</th><th>Эзэмшиж буй хувьцааны эзэмшлийн хувь</th></tr><tr><td>1</td><td>“Эн Си Ди Групп” ХХК</td><td>27.45%</td></tr><tr><td>2</td><td>Шагдарсүрэн Энхбаяр</td><td>10.00%</td></tr><tr><td>3</td><td>“Юнимедиа Солюшнс” ХХК</td><td>8.42%</td></tr><tr><td>4</td><td>“Могул” ХХК</td><td>8.27 %</td></tr><tr><td>5</td><td>ККТТ ХХК</td><td>7.30%</td></tr><tr><td>6</td><td>“Айкор Партнерс” ХХК</td><td>7.11%</td></tr><tr><td>7</td><td>“Рентракс” ХК</td><td>5.61%</td></tr><tr><td>8</td><td>Бусад хувьцаа эзэмшигчид /Олон нийт/</td><td>25.85%</td></tr><tr><td></td><td>Нийт дүн</td><td>100.00%</td></tr></table>	№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эзэмшиж буй хувьцааны эзэмшлийн хувь	1	“Эн Си Ди Групп” ХХК	27.45%	2	Шагдарсүрэн Энхбаяр	10.00%	3	“Юнимедиа Солюшнс” ХХК	8.42%	4	“Могул” ХХК	8.27 %	5	ККТТ ХХК	7.30%	6	“Айкор Партнерс” ХХК	7.11%	7	“Рентракс” ХК	5.61%	8	Бусад хувьцаа эзэмшигчид /Олон нийт/	25.85%		Нийт дүн	100.00%
№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Эзэмшиж буй хувьцааны эзэмшлийн хувь																													
1	“Эн Си Ди Групп” ХХК	27.45%																													
2	Шагдарсүрэн Энхбаяр	10.00%																													
3	“Юнимедиа Солюшнс” ХХК	8.42%																													
4	“Могул” ХХК	8.27 %																													
5	ККТТ ХХК	7.30%																													
6	“Айкор Партнерс” ХХК	7.11%																													
7	“Рентракс” ХК	5.61%																													
8	Бусад хувьцаа эзэмшигчид /Олон нийт/	25.85%																													
	Нийт дүн	100.00%																													
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл Инновэйшн Инвестмент ХК нь 2023.12.04-ний өдрөөс 2023.12.08-ны хооронд Монголын хөрөнгийн бирж дээр анхдагч зах зээлийн захиалга авч 8.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн. 2024 онд төлөвлөж байсны дагуу QPay төлбөрийн системийн суурь дэд бүтцийн шинэчлэлийн хүрээнд Суурь дэд бүтцийн сервер, тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах болон одоогийн сервер, тоног төхөөрөмжийг өргөтгөх чиглэлээр 1,061,274,656 төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авалт хийсэн бөгөөд үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн 15% буюу “Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа”-нд зориулагдах 1,247,994,608 төгрөгөөс зарцуулсан. Мөн 2024 оны 2 дугаар хагаст QPay үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлж, бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааг өргөжүүлэхтэй холбоотой кампанит ажлыг явуулж байгаа ба тус үйл ажиллагаатай холбоотой 135,948,166 төгрөгийн зардал гарсан. Үүнийг татан төвлөрүүлсэн хөрөнгийн “Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үйл ажиллагааны тэлэлт” хэсгээс зориулалтын дагуу зарцуулаад байна.																														

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан:

№	Хөрөнгө оруулалтын зориулалт	Зарцуулахаар төлөвлөсөн		Зарцуулсан
		Эзлэх хувь	Мөнгөн дүн	Мөнгөн дүн
1	Бэлэн бус төлбөрийн зах зээл дээрх үндсэн үйл ажиллагааны тэлэлт	22.5%	1,871,991,911	135,948,166
2	Дунд хугацааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалт хийх үйлажиллагаа	30.0%	2,495,989,215	0
3	Техник, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг сайжруулах үйл ажиллагаа	15.0%	1,247,994,608	1,061,274,656
4	“ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр	25.0%	2,080,003,050	2,080,003,050
5	Олон улсын зах зээлд үйл ажиллагаа өргөжүүлэхтэй холбогдуулан хүний нөөц, менежментийн ур чадварыг сайжруулах	7.5%	623,985,266	0
	Нийт	100%	8,319,964,050	3,277,225,872

2023 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 25% буюу “ККТТ” ХХК-ийн эзэмшиж буй 9,244,458 ширхэг энгийн хувьцааны төлбөр болох 2,080,003,050 төгрөгийг зориулалтын дагуу ККТТ ХХК руу шилжүүлсэн. Тайлант жилд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 39%-ийг зориулалтын дагуу зарцуулаад байгаа ба үлдсэн хөрөнгийг зориулалтын дагуу 2025 болон 2026 онуудад зарцуулахаар төлөвлөж байна.

9. Ногдол ашгийн мэдээлэл

Ногдол ашгийн мэдээлэл:

Ашгаас ногдол ашиг хуваарилсан санхүүгийн жил	Шийдвэрийн огноо, Тогтоолын №	Нэгж хувьцаанд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ	Ногдол ашиг тараасан огноо:
2023	2024.02.15 № 02/02	21.63₮	2024.04.15
2024 оны эхний хагас жил	2024.12.04 № 05/14	20₮	2024.12.24
2024 оны сүүлийн хагас жил	2025.02.17 №05/30	20₮	-

2023 оны цэвэр ашгаас нийт 4 тэрбум төгрөгийг 2024.04.15 ны өдөр хуваарилсан.

2024 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд нийт 40₮, нийт 7.4 тэрбум төгрөг хуваарилахаар шийдвэрлэж 3.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2024 оны 12 дугаар сард ҮЦТХТ-өөр дамжуулан тараасан.

10. Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

Банкны 1 гүйлгээний ард 1 ширхэг А4 цаас ашиглагддаг гэж үзвэл QРau үйлчилгээ нь 2024 онд 176.6 сая ширхэг цаас хэмнэснээр 21'208 мод, 65'117 тонн ус, 3'000м3 нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг тус тус хэмнэсэн байна.

Үүнээс гадна Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй цахим бизнесүүдийн 90-ээс дээш хувь нь QРau үйлчилгээг голлох төлбөрийн хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь онлайн бизнесүүдийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Төрийн бүх үйлчилгээнд QРau холболтыг хийснээр иргэд олон нийтийн төрийн үйлчилгээ авах хүртээмжийг нэмэгдүүлж, түгжрэл, цаг хугацаа хэмнэхэд бодитой хувь нэмэр оруулж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Эрдэнэманх

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:



Мэдээлэл бэлтгэсэн, хянасан этгээдийн гарын үсэг, огноо:

Хянасан:

Овог, нэр: Б.Энхболд

Албан тушаал: Санхүү эрхэлсэн захирал

Гарын үсэг: 

Бэлтгэсэн:

Овог, нэр: П.Мөнхтуяа

Албан тушаал: Хөрөнгө оруулагчийн харилцаа хариуцсан менежер

Гарын үсэг: 